

УДК 9030.85

ТОД ҮСГИЙН КА-ГИЙН ОНЦЛОГ

Хөхийн Бямбажав

Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль,
Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн докторант.
E-mail: kbyambajav@gmail.com

Товчлол

Тод үсэгт байдаг авиазүй болон үсэгзүйн талаараа өвөрмөц онцлогтой нэгэн үсэг бол хамжих ка үсэг юм. Өмнө нь эрдэмтэд судалгаандаа хэрхэн авч тусгасныг үүнд нэгтгэн дүгнэлээ. Ка үсгийн онцлогийг тодруулахын тулд сонгодог монгол бичгийн өмнөх үеийн бичгийн дурсгалууд, тод үсгийн дурсгалуудыг гол баримт болгон ашиглав. Энэхүү үсгийн уг язгуур нь юу болох, тод үсгийн хөгжлийн явцад энэ үсгээр зарим нутагт өөр авиаалбарыг орлуулан тэмдэглэсэн, галиг үсгийг болон гадаад үгийг тэмдэглэх болсон шалтгаан зэргийг уйгаржин монгол бичгийн уламжлал болон тод бичгийн онцлог, үсэгзүйн үүднээс тодруулан тайлбарлаж, өөрийн саналаа дэвшүүлэв.

Түлхүүр үг

Тод үсэг, үсэгзүй, хамжих ка үсэг.

UDC 9030.85

FEATURES OF THE LETTER K IN THE OIRAT WRITING “TODO BICHIG”

Khukhiin Biambazhav

Doctoral student at the Chair of Mongolian Language and Linguistics,
School of Sciences, National University of Mongolia.
E-mail: kbyambajav@gmail.com

Annotation

The character *ka*, notable for its phonetic and orthographic uniqueness, is a distinctive letter in the Todo Script. This study reviews how previous scholars have addressed this letter in their research. In order to clarify the characteristics of the *ka* letter, the monuments of pre-classical Mongolian script, monuments of Todo script were used as primary sources. The study explores the origin of this letter, analyzes the reason why it came to represent different phonetic sounds in certain regions during the development of Todo script, and why it came to be used for transliterations and loan words from the perspective of Uyghur-Mongolian script traditions, the distinct features of Todo script, and its orthography, while also presenting the author's own insights.

Key words

Clear script, orthography, letter *ka*.

О Р Ш И Л

Монголчуудын бичиг үсгийн түүхэнд томоохон байр суурийг эзлэх үсгийн нэг болох XVII зуунд уйгаржин-монгол бичгийн суурин дээр зохион хэрэглэж ирсэн “тодорхой монгол үсэг” буюу тод үсэг бөгөөд угийн уйгуржин-монгол бичгээ тодорхой болгож монгол хэлний авианы түүхэн хувьслыг баримжаалан тогтоож, тус тус ялган тэмдэглэх болсон томоохон ололт бүхий үсэг юм.




Тод бичгийн үсэггүй болон хэлний зүйн талаас хийсэн эрдэмтэдийн судалгаа цөөнгүй бий. Тод бичигт үсэггүйн хувьд өвөрмөц гэж үздэг. *ᠵ*-*к* үсгийн талаар анхлан өөрийн судалгааны бүтээлдээ оруулсан эрдэмтэдийн нэг бол монголч эрдэмтэн А. Попов (1847) юм. Тэрвээр Халимаг хэлний зүйн бүтээлдээ: Энэ “*к* үсэг нь дуудлагаараа галигийн *к* бөгөөд монгол үгэнд *йа*, *йо* үеийн өмнө байрлана. Жишээ нь: Тод үсэгт *зокдоху* бөгөөд монгол бичгийн *цзokiaxy* –ын оронд бичнэ” (Попов, 1847: 13) гэж товчхон дурдсан байна. А. Попов *к* үсгийг тод бичгийн цагаан толгойд оруулсан боловч санскрит, төвд үсгийг тэмдэглэх галиг үсгийн аймагт бас оруулсан байна.




Эдэмтэн А. Поповтой нэгэн үед бүтээлээ хэвлүүлсэн эрдэмтэн бол нэрт монголч А. А. Бобровников (1849) юм. Тэрвээр “*Монгол-Халимаг хэлний зүй*” хэмээх бүтээлдээ: “Тод бичгийн (*ка*) үсэгтэй тохирох үсэг Монгол бичгийн хэлэнд үгүй бөгөөд энэ нь зөвхөн урт *ā*, *ō*, *ū* эгшгийн өмнө тохиолдоно. Энэ үсэг ерөнхийдөө орос хэлний *к* үсэг шиг дуудагдах бөгөөд угийн дунд эгшгийн өмнө заримдаа *g* үсэг шиг дуудагдана” гээд, жишээ болгож *такā*, *угāху*, *сакūsунь* (Бобровников, 1849: 10) зэрэг үгсээр харуулсан байна. А. А. Бобровников энд *монгол бичгийн хэлэнд үүнтэй ижил үсэг үгүй* гэсэн нь монгол бичгийн эртний дурсгалуудад тохиолддог *-qiya*, *-qiya*, *-qiū* хэлбэртэй холбоогүй гэж үзсэн үү, эсвэл энэ талаар анхаараагүй буй юу. Харин *үгийн дунд эгшгийн өмнө заримдаа g үсэг шиг дуудагдана* гэж тодорхойлсныг нь цаашид анхааран судалж үзэх хэрэгтэй байна.

Дээрх хоёр эрдэмтнээс нилээд хожим Унгарын монголч эрдэмтэн Д. Кара (György Kara) энэ *к* үсгийн тиг зурлагын хэлбэр тал дээр ажиглалт хийж, муруй хэлбэртэй нэмэлт зураас (диакритик) бүхий гэж тодорхойсон байна. Мөн өгүүлэхүйн эрхтний хувьд хэлний урдуурх бус, хэлний угаар хэлэгддэг, авиа зохицохын хувьд ялгаагүй хагас-дуутай буюу дуутай хөөмийшсөн хамжих авиаг илэрхийлдэг бөгөөд Зая бандидын зохиосон тод үсэгт “цэвэр Ойрад” гэж хүлээн зөвшөөрч болох цорын ганц үсэг байдаг нь энэхүү хэлний угийн урт эгшгийн өмнөх тагнайшсан хамжих *К* үсэг юм (Кара, 1972: 81-82) гэж үзжээ.

Монголын эрдэмтэдээс Х. Лувсанбалдан (1975) тод үсгийн *ᠵ*-ка нь уйгаржин монгол үсгийн *heth+iya+iya* -гийн нийлбэрийн өмнө тохиолдож байна. Жишээ нь:

Мо.  taqiy-a,  takiy-a, То.  takā;

Мо.  saq'iylsun,  sakiylsun, То.  sakuusun;

Мо.  joqiyal,  jokiyal, То.  zoköl гэх мэт.

Зая бандид уйгаржин үсгийн  (*heth+iya+iya*) -гаас уламжилж *к* үсгийг авсан бололтой (Лувсанбалдан 1975:30) гэжээ.

Тод үсгийн талаар хэд хэдэн сонирхолтой судалгааны өгүүлэл бичсэн эрдэмтэдийн нэг бол Г. Жамьян юм. Түүний *“Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудал”* (1970) гэдэг өгүүлэл эрдэмтэдийн анхаарлыг татжээ. Тэрвээр тод үсгийн үсэгзүйн талаар бичсэн өгүүлэлдээ: Зая бандида зөвхөн ойрад аялгууны эр үгст тохиолдох *k* авиа тэмдэглэх үсгийг шинээр зохиожээ. Энэ нь эртний монгол хэлний *-iya, iya, -iyu* нийлбэрийн өмнө байсан хамжих *k* тохирдог. Жишээ нь: *sakiyusun-sakuūsun, dzokiyāl-zokoāl, takiya-ā-takaā* (Жамьян, 1993: 60) гэх мэт жишээ татан тайлбарлажээ.

Мөн эрдэмтэн Ц. Шагдарсүрэн монголч эрдэмтэн Д. Кара (György Kara)-гийн дээр өгүүлсэн саналыг дэмжин, “хэлний арын урт *a, o, й* эгшигийн өмнө тохиолддог, тагнайн хамжих гийгүүлэгчийг тэмдэглэдэг *K* үсэг л зөвхөн ойрод аялгууны онцлогийг тусгасан гэж үзэж болно” (2001: 118) гэжээ.

Тод үсгийн үсэгзүйн судалгаа хийсэн дээрх эрдэмтэдийн саналыг нийтэд нь ажиглан үзвэл тод бичгийн *k* үсгийн талаар аль нэгэн хэмжээгээр судалгаандаа тусгасан боловч бидний тодруулахыг хүсэж буй зүйлийг бүрэн тод илрүүлэн гаргасангүй. Зарим эрдэмтэд энэ *k* үсгийг зөвхөн ойрад аялгууны онцлогийг тусгасан, мөн харь хэлний үг тэмдэглэхэд зориулагдсан гэж үзсэн байна. Зарим саналыг дагах боловч *k* үсгийг харь хэлний үгийг тэмдэглэх шинэ үсэг болгон нэмж зохиосон гэх тал дээр учир дутагдалтай зүйлүүд ажиглагдаж байна.

Харин эрдэмтэн Х. Лувсанбалдан, Г. Жамьян нарын дэвшүүлсэн санал бидний анхаарал хандуулж байгаа гол санааг гаргасан байна. Монголчууд согд-уйгурын үсгийн *heth+iya+iya* гэсэн үндсэн тэмдэгтийг уйгуржин-монгол бичигт шууд авч хэрэглэсэн тэр цагт *qiya, qiya* хэлбэрийг Зая бандида тод үсэгтээ шууд тусган *kaā, koā, kii* хэлбэртэй болгон зохиожээ гэж үзээд үүнийг уйгуржин-монгол бичгийн дурсгалуудтай холбон, энэ талаар хийсэн эрдэмтэдийн судалгааг анхааран үзэх нь бидний энэ удаагийн судалгааны гол зорилго болох юм.

Зая бандидын зохиосон “Үсгийн найрлага” хэмээх үсэгзүйн зохиолынхоо монгол үсгийн цагаан толгойн хэсэгт тусгахдаа *ka, ko, ku* гэж оруулсан *k* үсгийн онцлогийг тодруулахын тулд тод бичгийн дурсгалууд болон монголчууд согд-уйгурын үсгийн үндсэн тэмдэгтийг шууд авч хэрэглэсэн тэр цагийн буюу өөрөөр хэлбэл сонгодог монгол бичгийн өмнөх үеийн бичгийн дурсгалуудаас эхлэн мөшгиж, тод үсэг зохиогдох үе хүртлэх цаг үеийг хамаарах баримтуудыг гол болгон ашиглах болно. Ингэхдээ түүхэн хэл шинжлэлийн аргагүй, үсэгзүйн судалгааны аргыг хэрэглэж, судалгаа баримтаар баталгаажуулан тод бичгийн *k* үсэг нь зөвхөн ойрад аялгууны онцлогийг тусгасан уу, эс гэхүл нийт монгол хэл аялгуунд бүрэнээ тохируулж уйгуржин монгол бичгээс онцлогийг нь тусган оруулсан эсэх, мөн хожимын үед энэ үсгийг гадаад үгийн *k* үсгийг тэмдэглэж ирсэн нь зүйд нийцэх үү, эсвэл учир дутагдалтай зүйл үү гэх зэрэг асуудалыг монгол бичгийн уламжлал болон тод бичгийн онцлог, үсэгзүйн үүднээс холбон судалж тодруулан гаргахыг хичээлээ.

1. ГАЛИГ ҮСЭГ БУЮУ ХАРЬ ХЭЛНИЙ ҮГЭНД *ᠵ* КА ҮСГИЙГ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Тод бичгийн *ka* үсгийг ямар учраас харь хэлний үгийг тэмдэглэх болсон, мөн санскритын али, гали үсгүүдийг тэмдэглэж ирсэн бичвэрүүдэд анхаарал хандуулах хэрэгтэй юм.

Тод бичгийн түрүү үеийн дурсгалуудад зөвхөн уйгаржин-монгол бичгийн *qīya*, *qīyu* нь *kaā*, *koā*, *kuī* гэсэн бичлэгтэй байсаар ирсэн. Хожим үед галиг үсгийн оронд хэрэглэсэн нь XIX зууны үеэс Оросын эрдэмтэдийн тод бичгээр хийсэн судалгааны материал, эх сурвалжуудад ихэвчлэн тохиолддог.

Жишээ: Санскрит, төвд, орос хэлнээс орсон үгсийг тэмдэглэсэн нь

ᠰᠢᠯᠠᠪᠠᠩᠭᠠ *kalabangya* (Позднеев., 279) < *Skt.* कलिवङ्क: *kalaviṅkaḥ* - галбинга шувуу

ᠰᠢᠷᠠᠳᠢ *karudi* (Попов., 327) < *Skt.* गरुड: *garuḍaḥ* - гарди шувуу

ᠰᠢᠮᠪᠠ *kamba* (Позднеев., 279) < *Tib.* ᠰᠠᠮᠪᠠ - агь өвс, хамба шарилж

ᠰᠢᠷᠰᠤᠮ *korsum* (Позднеев., 279) < *Tib.* ᠰᠢᠷᠰᠤᠮ *‘khor gsum* (ном хаялцах үеийн)

ᠪᠠᠭᠠᠵᠢ - *baḡāji* (Бāза-Бакши., 4) < *Rus.* багаж (ачаа, тээш)

ᠰᠢᠷᠠᠭᠤᠯ *koruul* (Позднеев., 279) < *Rus.* король (хөзрийн ноён)

ᠰᠢᠯᠠᠪᠠᠩᠭᠠ (*kalabangya*) гэдэг үгийг *Skt.* कलिवङ्क: *ᠰᠢᠯᠠᠪᠠᠩᠭᠠ* гэж бичдэг. Тэргүүн га нь “Үсгийн найрлага”-д *ᠰ* гэж санскрит, төвдийн *ᠰ* хэлбэр махбодыг монгол үсэгт шингээн зохиож журамласан үсгүүдийн нэг юм.

ᠰᠢᠷᠠᠳᠢ -*karudi* (Попов, 1847: 327) < *Skt.* गरुड: *garuḍaḥ* — гарди шувууны нэрийг тод бичгийн дурсгалуудад *ᠰᠢᠷᠠᠳᠢ* - *karuḍa* гэж уг санскритыг нь баримтлан, эсвэл *ᠰᠢᠷᠠᠳᠢ* гэж тогтсон бичлэгтэй байдаг. Тэгвэл яагаад *ᠰ* гэж бичих ёстой байтал *ᠰ* гэж бичих болов гэдэг асуулт гарч байна.

Мөн төвд хэлний хорсум (*‘khor gsum*) хэмээх үгийг угтаа Зая бандидын намтар “Сарны гэрэл”- *ᠰᠢᠷᠰᠤᠮ* (*korsum*) гэж тодорхой бичсэн байтал эрдэмтэн Позднеев “Халимаг-Орос толь бичиг”-т энэ хэсгийг эшлэж оруулахдаа *ᠰᠢᠷᠰᠤᠮ* (*korsum*) гэж бичсэн байна (1911). Харин төвдийн *ᠰᠢᠷᠰᠤᠮ* (*kha, khi, khu, khe, kho*) үсгийг Зая бандидын зохиосон “Үсгийн найрлага”-д *ᠰᠢᠷᠰᠤᠮ* гэж тогтоосон байдаг. Дээрх санскрит, төвдөөс орсон хоёр үгийн жишээг Зая бандидын зохиосон “үсгийн найрлага”-д журамласнаас үзвэл *ᠰ* *k* үсгийг хэрэглэх ёсгүй юм.

“Үсгийн найрлага”-ын монгол хэлний үсгийн цагаан толгойн хэсэгт “үгийн эхэнд орохгүй, монгол хэлний үгийн дунд *ᠰ-ka*, *ᠰ-ko*, *ᠰ-ku* гэж зөвхөн ардаа *a*, *o*, *u* эгшигтэй орно” гэж товч тодорхой илтгэн үзүүлсэн байдаг. Харин галиг үсгийн буюу санскрит, төвд үсгийг тэмдэглэх галигт энэ *ᠰ-ka* үсгийг огт хэрэглээгүй байна. Энэ нь зөвхөн монгол хэлний үгийг тэмдэглэх, тэр дундаа хэлний авианы хувьслын байдлыг харуулсан үсэг юм.



Орос хэлнээс орсон үгийг тэмдэглэхдээ тод үсгийн энэ *ᠰ ka* үсгийг *ᠰ-ka*, *ᠰ-ko*, *ᠰ-ku*, *ᠰ-ki* болгож ашигласан нь цөөнгүй байна. Зая бандидын анх тогтоосон тэр галиг үсгийн зарчмыг баримтлаагүй, зөвхөн тухайн хэлний ярианы дуудлага, авианы онцлогт ойртуулж бичиж байсан хэрэг юм. Тод үсгийн энэ хамжих *x* үсгийг XIX-р зуунаас ихэвчлэн Оросын эрдэмтэд судалгааны бүтээл, сурах бичиг, толь бичиг сэлтэд анх ашигласнаас улбаатай юм. *ᠰ ka* үсгээр харь хэлний үгийг тэмдэглэх нь Зая бандидын зохиосон “Үсгийн найрлага”-д журамласан ёстой тохирохгүй болно.


2. УЙГУРЖИН БИЧГИЙН УЛАМЖЛАЛЫГ ХАДГАЛСАН НЬ


Зая бандида сонгодог монгол бичгийн өмнөх үеийн *-iya*, *-iua*, *-iyu* нийлбэрийн өмнө байсан хамжих *q* — тай тохирдог уйгаржин үсгийн *heth* (*ᠬ*) -аас уламжилж


ka үсгийг авсан гэдгийг өмнө нь бид нэгэнтээ дурдсан билээ. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад *qiya*, *qiya*, *qiya* гэсэн нийлмэл хэлбэр цөөнгүй тохиолдоно. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалыг судалсан эрдэмтэн Д. Төмөртоогоо (Tumurtogoo, 2006) нарын бүтээлийг ашиглан тод үсгийн дурсгалуудтай харьцуулж хэдэн жишээ татъя.

MM *joqiya:qu* (BT.162a)  > TW *jokōxu* 

MM *toqiya:ldu* (Jig. 18)  > TW *tokōldu* 

MM *uqiya:ju* (Bod. 17a5)  > TW *ukāji* 

MM *doqiya:r* (Sub.I:4b)  > TW *dokūur* 

MM *saqiya:lsun* (Turf.32:5)  > TW *sakuusun* 


Тэгвэл энэ үсэгзүйн өвөрмөц онцлогтой зүй тогтолтой “-i” эгшгийн өмнө эр үгийн “q-” орсон бичлэг сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад тохиолддогийг эрдэмтэд хэрхэн дүгнэснийг авч үзье.

Орчин цагийн монгол хэлний “Х, Г” авиалбарыг монгол бичигт тэмдэглэхдээ, эр үгэнд  (q/γ) эм үгэнд  (k/g) гэж хоёр янзаар бичих бөгөөд  -ийн дараа “-и” эгшиг ордоггүй тогтсон журамтай билээ. Гэтэл сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад *qi* / *γi*, гэсэн нийлмэл хэлбэр цөөнгүй тохиолдоно. Эртний монгол хэлний фонемын системийг нэхэн сэргээсэн эрдэмтэд тухайн үед эр, эм үгэнд тохиолдох чанга, хөндий хоёр янзын “и” (*i*: *i*) авиалбар байсан гэдгийг нийтэм тайлбарласан билээ.

Согд-уйгурын үсэгт эр, эм “и” (*i*: *i*) авиалбарыг нэгэн тэмдэгтээр тэмдэглэдэг зүй тогтлыг шууд тусгаснаас үүдэлтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, монголчууд согд-уйгурын үсгийн үндсэн тэмдэгтийг шууд авч хэрэглэсэн тэр цагт “а, е” авиалбарыг нэгэн тэмдэгтээр тэмдэглэж байсанчлан эр, эм “и” (*i*: *i*) авиалбарыг ч мөн адил бичиж байжээ (Заяабаатар, 2011: 49).

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн болон тод үсгийн дурсгалуудаас жишээ татан харьцуулж “-i” эгшгийн өмнө эр үгийн “q-” орсон бичлэгийг үзүүлбэл:

 qilbar  qilinča  taqil  joqistu (BT.1312)

 kilbar  kilinče  takil  jokiston (SNRTodo)

Дээр дурдсан эрдэмтэдийн дүгнэн тайлбарласны дагуу ажиглан үзвэл тод үсэгт эр, эм үгэнд тохиолдох чанга, хөндий хоёр янзын “и” (*i*: *i*) авиалбарын уламжлал харагдахгүй байна.

Тод үсэгт дээрх мэт тогтсон бичлэгтэй байдаг. Гэтэл *qiya*, *qiya*, *qiya* хэлбэрийг тод үсэгт *kia*, *kio*, *kiya* гэсэн хэлбэртэй болсонгүй. Харин  -kaā,  -koō,  -kiui

гэж онцгой хэлбэртэй болсны учрыг бид үзэхдээ ᠵ нь авиалбарын хувьд саармаг (i) нь эрэс-д эр эрэс хийгээд эм эрэс хоёр буй ($\text{jirüken-ü tolta.}, 9a$) гэж “Зүрхэний толт” тэргүүтэн хэлний зүйн эх сурвалжаас эртний монгол хэлний фонемын системийг нэхэн сэргээсэн эрдэмтэд тухайн үед эр, эм үгэнд тохиолдох чанга, хөндий хоёр янзын “и” ($i: i$) авиалбар буй гэж баталсанчлан хожим тод үсгийн энэ ᠵ нь $q+i$ (ᠵ) –ийн хэлбэрийг агуулж, үүний дээр монгол хэлний ойрад аялгуунд үүссэн “ā, ō, uu” урт эгшгийн онцлогоос шалтгаалжээ гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Тод үсгийн “Үсгийн найрлага”-аар журамлан тогтоосон тэр ёсоор бол XIX зууны үеэс ялангуяа Халимагийн хэл аялгуунд суурьлан тод үсэгт хийгдсэн ганц нэг нэмэлт тэмдгийн нэг болох энэ ᠵ үсэг нь санскрит, төвд хэлэнд байдаг энэ ka ᠵ , kha ᠵ -г тэмдэглэх тусгаар үсэг байсаар атал k ᠵ үсгээр тэмдэглэсэн нь нэгдүгээрт галигийн ka ᠵ үсгийн дүрс хэлбэртэй андуурч харь хэлний үгийг тэмдэглэх ёстой гэж үзсэн, хоёрдугаарт Зая бандидын анх тогтоосон тэр галиг үсгийн зарчмыг баримтлаагүй, зөвхөн тухайн хэлний ярианы дуудлага, мөн орос хэлний онцлогт тааруулж бичиж байснаас үүджээ. Цаашид энэ үсгийг галиг үсэгт хэрэглэхгүй байх нь зохимжтой гэж үзэж байна.

Уйгуржин бичгийн уламжлалыг хадгалсны хувьд ийм тохиолдлыг санамсаргүй, үсгийн тиг зурлага хэмнэх оролдлого гэхээс илүүтэй монгол бичгийн зөв бичихзүйн тулгуур зарчим чанга, хөндийн зохицолд “Г, Х” гийгүүлэгч онцгой үүрэг гүйцэтгэж байсны бас нэг баримт бөгөөд эртний монгол хэлний эр, эм үгэнд тохиолдох чанга, хөндий хоёр янзын “и” ($i: i$) авиалбар байсны нөлөө уйгуржин-монгол үсгээр дамжин тод үсэгт энэ ka үсэг бий болсон гэж үзэж байна.

Орчин цагийн монгол хэлний “Х, Г” авиалбарыг монгол бичигт тэмдэглэхдээ, эр үгэнд $\text{ᠵ} : \text{ᠵ}$ (q/y) эм үгэнд $\text{ᠵ} \text{ᠵ}$ (k/g) гэж хоёр янзаар бичих бөгөөд $\text{ᠵ} : \text{ᠵ}$ -ын дараа “-и” эгшиг ордоггүй журам тогтохоос өмнө тод үсэг зохиогдож, үсэгзүй, зөв бичих зүй нь тогтон хэвшчихсэн байсан учраас сонгодог монгол бичгийн өмнөх үеийн $\text{heth} + \text{iya} + \text{iya}$ хэлбэрийн уламжлалыг хадгалан kāā , kōā , kūū болгон журамлажээ хэмээн үзэж байна.

Равжамба Зая бандида Намхайжамц тод үсэг хэмээх шинэ үсэг бичиг зохиосон бус монгол бичгийн эртний уламжлалыг нэхэн сэргээж, тодотгон тусгаж өгсний нэгэн жишээ энэ kā үсгийн онцлог юм.

Товчилсон нэрийн тайлал

- Bod. — The Bodhicaryāvatāra from Olon Süme
BT — Bodhicaryāvatāra by Chos-kyi ‘od-zer (1312)
BTTodo — Bodhicaryāvatāra todo
Jig. — The Mongolian Inscription in Memory of Jigüntei (1338)
MM — Midle Mongolian
Mo. — Монгол бичиг
Rus. — Орос хэл

Skr. — Санскрит хэл
SNR — Subhaṣitaratnanidhi by Sonom Gara
SNRTodo — Subhaṣitaratnanidhi todo script
Sub. — A Mongolian Version of Subhāṣitaratnanidhi
Tib. — Төвд хэл
To. — Тод үсэг
Turf. 32 — Turfan-Collections, A fragment of an Edict
TW — Тод бичгийн хэл

Ном зүй

- Бобровников, А. (1849). *Грамматика монгольско-калмыцкого языка*. Казань.
- Жамьян, Г. (1970). Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд. *SM*. VII. 20. Улаанбаатар. 257–270.
- Жамьян, Г. (1993). Ойрадын Равжамба Зая бандида Намхайжамцын зохиосон тод үсэг. *Kele ba orčiγulya*. Көкеqota. 1. 50–62.
- Заяабаатар, Д. (2011). *XIII–XVI зууны монгол бичгийн дурсгалын авиазүй, үгзүйн тогтолцоо*. Улаанбаатар.
- Кара, Д. (1972). *Книги монгольских кочевников*. Москва.
- Лувсанбалдан, Х. (1975). *Тод үсэг, түүний дурсгалууд*. Ред. Ц. Дамдинсүрэн. Улаанбаатар.
- Позднеев, А. М. (1911). *Калмыcko-русский словарь в пособие к изучению русского языка в калмыцких начальных школах*. СПб.: Тип. Имп. Акад. наук.
- Попов, А. (1847). *Грамматика калмыцкого языка*. Казань.
- Шагдарсүрэн, Ц. (2001). *Монголчуудын үсэг бичигийн товчоон: Үсэг зүйн судлагаа*. Улаанбаатар: Урлах эрдэм.
- Kara, G. (2009). Dictionary of Sonom Gara's *Erdeni-yin sang*: A Middle Mongol Version of the Tibetan *Sa-skya legs bshad*: Mongol-English-Tibetan (Brill's Inner Asian library; v. 23). Leiden: Boston.
- Kara, G. (2011). The “jirüken-ü tolta” Ascribed to Chos-kyi 'Od-zer. *Mongolian Studies*. 33. 49–72.
- Tumurtogoo, D. (2006). *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII–XVI centuries): Introduction, Transcription and Bibliography*. With the Collaboration of G.Cecegdari. Language and Linguistics Monograph Series A-11. Taipei: Institute of Linguistics, Academia Sinica.

References

- Bobrovnikov, A. (1849). *Grammar of the Mongolian-Kalmyk language*. Kazan.
- Jamyan, G. (1970). Tod ysgiin zöv bichih duremd urt egshigiγg kherkhen temdeglesen tuhay asuudald [To the problem of how long vowels are marked in clear script]. *SM*. VII. 20. Ulaanbaatar. 257–270.
- Jamyan, G. (1993). Oyradyn Ravzhamba Zaya bandida Namkhayzhamtsyn zohioson tod useg [Clear script's letters composed by Oirad Ravjamba Zaya bandida Namkhajamts]. *Kele ba orčiγulya*. Kөkeqota. 1. 50–62.
- Kara, G. (1972). *Books of Mongolian nomads*. Moscow.
- Kara, G. (2009). Dictionary of Sonom Gara's *Erdeni-yin sang*: A Middle Mongol Version of the Tibetan *Sa-skya legs bshad*: Mongol-English-Tibetan (Brill's Inner Asian library; v. 23). Leiden: Boston.
- Kara, G. (2011). The “jirüken-ü tolta” Ascribed to Chos-kyi 'Od-zer. *Mongolian Studies*. 33. 49–72.

- Luvsanbaldan, H. (1975). *Clear script and its monuments*. Ed. Ts. Damdinsuren. Ulaanbaatar.
- Pozdneev, A. M. (1911). *Kalmyk-Russian dictionary as a manual for studying Russian in Kalmyk primary schools*. SPb.: Type. Imp. Acad. of sciences.
- Popov, A. (1847). *Grammar of the Kalmyk language*. Kazan.
- Shagdarsuren, C. (2001). *Mongolchuudyn useg bichigiin tovchoon: useg zuyn sudlaga*. Ulaanbaatar: Uurlah erdem.
- Tumurtogoo, D. (2006). *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII–XVI centuries): Introduction, Transcription and Bibliography*. With the Collaboration of G.Cecegdari. Language and Linguistics Monograph Series A-11. Taipei: Institute of Linguistics, Academia Sinica.
- Zayaabaatar, D. (2011). *Phonology and lexical system of Mongolian written monuments of the 13th-16th centuries*. Ulaanbaatar.